



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 56

Эрдэнэт

“Багийн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр”
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн Ээлжит III хуралдааны 01 дүгээр тогтоолоор баталсан “Орхон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 9.1.4. дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Багийн хөгжлийг дэмжих” аймгийн дэд хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр гарган, шаардагдах төсөв, хөрөнгийг тухайн жилийн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, орон нутгийн төсөвт тусган батлуулж, биелэлтийн явцыг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулж байхыг аймгийн Засаг дарга /Д.Батлут/-д даалгасугай.

ДАРГА



П. ПҮРЭВЛХАГВА